

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР № 7

Хуралдаан 2013 оны гуравдугаар сарын 14-ны өдрийн 14 цаг 10 минутад эхэлж, 16 цаг 58 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 2 цаг 48 минут үргэлжлэв.

| № | Хэлэлцсэн асуудал | Гарсан шийдвэр |
|---|--|---|
| 1 | Агентлагийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргуулах тухай | <p>Төрийн албаны тухай хуулийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 34, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Норовын Тэгшбаяр, Цагаан-Өвгөний Жадамбаа, Дамдингийн Энхжаргал, Цэсэнгийн Пүрэвдорж, Бөхчулууны Пүрэвдорж, Пунсанцогвоогийн Мөнх-Очир, Аюурзанын Хүрэлшагай, Сэнгээгийн Буяндалай, Гаваагийн Түвшинбаяр, Сономцэрэнгийн Энх-Амгалан, Сүхбаатарын Чулуунбаатар, Гунгаажавын Өлзийбүрэн, Мөнхөөгийн Галбадрах, Ишбадамын Нарантуяа нарыг удирдах албан тушаалтны нөөцийн жагсаалтад бүртгэж</p> <p>а. Норовын Тэгшбаярыг Засгийн газрын тохируулагч агентлаг Цөмийн энергийн газрын даргын албан тушаалд;</p> <p>б. Цагаан-Өвгөний Жадамбааг Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи,</p> |

| | | |
|--|--|---|
| | | <p>шуудан, харилцаа, холбооны газрын даргын албан тушаалд;</p> <p>с. Дамдингийн Энхжаргалыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газрын даргын албан тушаалд;</p> <p>d. Цэсэнгийн Пүрэвдоржийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан тушаалд;</p> <p>е. Бөхчулууны Пүрэвдоржийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын даргын албан тушаалд;</p> <p>f. Аюурзанын Хүрэлшагайг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газрын харилцаа, геодез, зураг зүйн газрын даргын албан тушаалд;</p> <p>g. Сэнгээгийн Буяндалайг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын албан тушаалд;</p> <p>h. Гунгаажавын Өлзийбүрэнг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газрын тосны газрын даргын албан тушаалд;</p> <p>i. Мөнхөөгийн Галбадрахыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлэг, үржлийн газрын даргын албан тушаалд</p> <p>j. Ишбадамын Нарантуяаг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн төлөө үндэсний газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэгт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> |
|--|--|---|

| | | |
|----------|--|--|
| <p>2</p> | <p>Үндсэн хуулийн Цэцийн тамгын газар, Уул уурхайн яам, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас зохион байгуулсан төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх зорилго бүхий төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын дүн, уг шалгалтанд тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэж, бүртгэгдсэн иргэдээс онооны дарааллыг баримтлан өрсөлдсөн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай</p> | <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 56 дугаар зүйлийг баримталж, 2013 оны 02 дугаар сарын 22, 23-ны өдөр зохион байгуулсан Үндсэн хуулийн цэцийн Тамгын газар, Уул уурхайн яам, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын сул орон тоог нөхөх Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none"> 1. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн нэр бүхий нийт 186 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д тус тус бүртгэснийг 1, 2, 3 дугаар хавсралтаар тус тус батлах 2. Энэхүү тогтоолын нэгдүгээр зүйлд заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 14 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, нэрсийг 4, 5, 6 дугаар хавсралтаар тус тус батлах 3. Энэхүү тогтоолын хоёрдугаар зүйлд заасан нэр бүхий 14 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулахыг тус тусын томилох эрх бүхий албан тушаалтанд үүрэг болгох. |
|----------|--|--|

| | | |
|---|--|--|
| | | <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> |
| 3 | <p>Дундговь аймагт зохион байгуулсан төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх зорилго бүхий төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын дүн, уг шалгалтанд тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэж, бүртгэгдсэн иргэдээс онооны дарааллыг баримтлан өрсөлдсөн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай</p> | <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 56 дугаар зүйлийг баримталж, 2013 оны 2 дугаар сарын 7-ны өдөр Дундговь аймагт зохион байгуулсан Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Дундговь аймагт 2013 оны 2 дугаар сарын 7-ны өдөр зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн нэр бүхий нийт 17 иргэн, үүнээс 1 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д, нэр бүхий 16 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д тус тус бүртгэснийг 1, 2 дугаар хавсралтаар тус тус батлах.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэгдүгээр зүйлд заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д тус тус бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 1 иргэнийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр</p> |

| | | |
|---|---|--|
| | | <p>бүхий 4 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, нэрсийг 3, 4 дүгээр хавсралтаар тус тус батлах.</p> <p>3. Энэхүү тогтоолын хоёрдугаар зүйлд заасан нэр бүхий 5 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулахыг Дундговь аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн даргад үүрэг болгох.</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> |
| 4 | <p>Өмнөговь аймгийн Засаг даргаар ажиллаж байсан Б.Цэдэнсамбыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай</p> | <p>Төрийн албаны тухай хуулийн 17.11, Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>Өмнөговь аймгийн Засаг даргаар 1996-2000 онд томилогдон ажиллаж байсан Банзрагчийн Цэдэнсамбыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> |
| 5 | <p>Төрийн албаны мэргэшлийн шалгалтын Төв комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай</p> | <p>Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 63 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 3 дугаар зүйлийн 15 дахь хэсгийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны мэргэшлийн шалгалтын төв комиссын бүрэлдэхүүнийг</p> |

| | | |
|---|---|---|
| | | <p>хавсралтаар батлах.</p> <p>2. “Мэргэшлийн шалгалтын төв болон төрийн захиргааны төв байгууллагын салбар комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 54 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> |
| 6 | <p>Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлүүдийн 2012 оны үйл ажиллагааны тайлангийн нэгдсэн дүнг танилцуулах</p> | <p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.4, 3.7.1, 3.7.4, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 126 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.9, 3.7 дахь заалтыг баримталж, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлүүдийн 2012 оны үйл ажиллагааны тайланд үнэлгээ хийсэн тухай асуудлыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүдийн 2012 оны үйл ажиллагааны тайланд хийсэн үнэлгээг хавсралтаар батлах.</p> <p>2. Салбар зөвлөлүүдийн 2012 оны үйл ажиллагааны жилийн ажлын үнэлгээгээр:</p> <p>а. Аймаг дахь Салбар зөвлөлүүдээс Орхон, Булган, Өмнөговь аймгууд дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл,</p> <p>б. Яамны дэргэдэх Салбар зөвлөлүүдээс Батлан хамгаалах яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл,</p> <p>с. Агентлагийн дэргэдэх Салбар зөвлөлөөс Хил хамгаалах</p> |

| | | |
|--|--|---|
| | | <p>ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлүүд тэргүүлснийг тус тус сайшаан дурдах.</p> <p>3. Салбар зөвлөлийн 2012 оны үйл ажиллагааны үнэлгээгээр хангалтгүй үзүүлэлттэй ажилласан Завхан, Хэнтий, Говь-Алтай, Сүхбаатар аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар, Татварын ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлүүдийг үйл ажиллагаагаа сайжруулж ажиллахыг анхааруулах.</p> <p>4. Засгийн газрын шийдвэрээр шинээр байгуулагдсан яам, агентлагийн дэргэдэх Салбар зөвлөлүүдийг мэргэшил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ажлын алба (С.Цэдэндамба)-нд даалгах.</p> <p>5. Салбар зөвлөлүүдээс ирүүлсэн саналын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны төлөвлөгөөнд тусган ажиллахыг Ажлын алба (С.Цэдэндамба)-нд даалгах.</p> <p>6. Салбар зөвлөлийн ажиллах журмыг шинэчилж, үйл ажиллагааг үнэлж дүгнэх тогтсон аргачлал боловсруулж, 2013 оны II улиралд багтаан Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж ажиллахыг Зөвлөлийн орон тооны гишүүн (Т.Хадхүү)-д даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> |
|--|--|---|

| | | |
|---|---|---|
| 7 | <p>Бусад асуудал:</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн албаны зөвлөлийн 2013 оны үйл ажиллагааны үндсэн чиглэлийн төсөлтэй танилцах - Мария Барродосын айлчлалын талаарх мэдээллийг сонсох | <p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны үйл ажиллагааны үндсэн чиглэлийг зарчмын хувьд дэмжиж, санал дүгнэлтүүдийг тусгахаар болов.</p> <p>Төрийн албаны төв байгууллагуудын олон улсын хурлыг Улаанбаатарт зохион байгуулах бэлтгэлийг хангах талаар холбогдох байгууллагуудад санал тавьж шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзэв.</p> |
|---|---|---|

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ